

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 03 сарын 25-ны өдрийн  
13 дугаар тогтоолын хавсралт



**ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ  
СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

**ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ  
ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ**

НЭГ.Нийтлэг үндэслэл.....	2
ХОЁР.Гэрээний үндсэн нөхцөл .....	2
ГУРАВ.Тээвэрлэлт, хадгалалт, чанарын хяналт, төлбөр тооцоо .....	3
Тээвэр логистик.....	3
Агуулахын баримт, хадгалалт .....	3
Чанарын хяналт .....	4
ДӨРӨВ.Бусад.....	5
Хавсралт 1.....	7

## ЗЭСИЙН БАЯЖМАЛЫН АРИЛЖААНЫ ГЭРЭЭНИЙ СТАНДАРТ ТОГТООХ, МӨРДҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмаар “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/-аар арилжаалах зэсийн баяжмал /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ын гэрээний стандартыг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих, чанарын хяналтыг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журамд заасан үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.3. Тус журмыг Биржийн харилцагч, итгэмжлэгдсэн агуулах, терминал, лаборатори, тээвэрлэгч болон бусад оролцогчид дагаж мөрдөнө.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 2.1. Гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүн нь Засгийн газраас баталсан биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний нэр, төрөл, ангилалд нийцсэн тухайн үеийн хүчин төгөлдөр Монгол Улсын стандартад заасан чанарын үзүүлэлттэй байна.
- 2.2. Гэрээнд тусгагдсан бүтээгдэхүүний тоо хэмжээ нь хэлцэл хийгдсэн бүтээгдэхүүний тоо хэмжээтэй ижил байна.
- 2.3. Гэрээнд худалдагчаас ирүүлсэн чанарын үзүүлэлтийг тусгана.
- 2.4. Гэрээгээр арилжаалах зэсийн баяжмалын 1 багц нь 1000 тонн (нойтон метр тонн<sup>1</sup>) байна.
- 2.5. Гэрээний үнийг ам.доллороор илэрхийлэх ба “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам”-д заасны дагуу тогтооно.
- 2.6. Форвард гэрээний хувьд зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан гэрээний үнийг тохируулж болох бөгөөд үнийн тохируулгын нөхцөл, тооцох аргачлалыг тодорхой тусгана.
- 2.7. Арилжааны үед гэрээний үнийг тогтоохдоо худалдагч өөрөөр тогтоогоогүй тохиолдолд хамгийн багадаа тонн тутамд 5 ам.доллороор өсгөх замаар үнийг тогтоосон байна.
- 2.8. Гэрээний арилжааны дэнчингийн хэмжээг “Уул уурхайн бүтээгдэхүүний

<sup>1</sup>Худалдагчийн агуулахаас ачилт хийх үеийн чийгтэй жин

арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам"-д заасны дагуу тогтооно.

- 2.9. Спот гэрээ нь гэрээний төлбөр хийгдсэнээс хойш 1 сар хүртэл хугацаатай, форвард гэрээ нь 12 сар хүртэл хугацаатай байна.
- 2.10. Гэрээний дуусгавар болох хугацаа бүтээгдэхүүн нийлүүлж дуусах хугацаанаас хэтрэхгүй байна.
- 2.11. Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг нь гадаад улсын хилийн боомт дахь "зэсийн баяжмал ачиж буулгах талбай" байна.
- 2.12. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх, хүлээлцэх ажиллагааг энэ журамд нийцүүлэн гүйцэтгэнэ.
- 2.13. Гэрээгээр арилжаалагдах бүтээгдэхүүн нь кодоор илэрхийлэгдсэн байж болно.

## **ГУРАВ. ТЭЭВЭРЛЭЛТ, ХАДГАЛАЛТ, ЧАНАРЫН ХЯНАЛТ, ТӨЛБӨР ТООЦОО**

### ***Тээвэр логистик***

- 3.1. Бүтээгдэхүүнийг итгэмжлэгдсэн агуулах, терминалаас нийлүүлэх цэгт хүргэх ажиллагааг худалдагчтай гэрээ байгуулсан Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч гүйцэтгэнэ.
- 3.2. Худалдагч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн дугаар, хүргэлтийн маршрут, бүтээгдэхүүн, тоо хэмжээ, очих хугацааны талаар мэдээллийг итгэмжлэгдсэн агуулах, терминалд бүтээгдэхүүнийг хүргэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
- 3.3. Худалдан авагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Худалдагч нь бүтээгдэхүүний гэрээнд заасан газарт хүргэх хүртэл хугацааны тээвэрлэлтийн эрсдэлийг хариуцна.
- 3.4. Тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгч нь тээвэрлэлтийн гэрээ байгуулсан этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 3.5. Худалдан авагч Биржийн итгэмжлэгдсэн тээвэр логистикийн үйл ажиллагаа эрхлэгчийг ашиглахгүйгээр бүтээгдэхүүнийг хүлээн авах бол ачилт хийгдсэнээр хүргэлтийн үйл ажиллагаа дууссан гэж үзнэ.

### ***Агуулахын баримт, хадгалалт***

- 3.6. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, ачилт хийж дуусах хүртэл чанар, тоо хэмжээ, аюулгүй байдлыг хариуцна.
- 3.7. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хадгалахдаа үндэсний холбогдох стандартад заасан хадгалалтын нөхцөлийг баримтлахаас гадна дараах нөхцөлийг бүрдүүлж ажиллана:
  - 3.7.1. камерын хяналтын системийг бүрдүүлсэн байх;
  - 3.7.2. бүтээгдэхүүний овоолгын нэршлийн самбартай байх.
- 3.8. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь Биржээр арилжих, арилжсан бүтээгдэхүүнийг хүлээн авч, энэ журмын Хавсралт 1 /цаашид "агуулахын баримт" гэх/-г үйлдэн Биржид ирүүлнэ.

- 3.9. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь итгэмжлэгдсэн лабораториор дээж авхуулах, шинжилгээ хийлгэх үйл ажиллагаанд хамтарч ажиллана. Худалдагч, эсхүл брокер нь шинжилгээний дүнг Биржид ирүүлнэ.
- 3.10. Худалдагч нь худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу бүтээгдэхүүний төлбөрийг хүлээн авсан тухай баримтыг Биржид ирүүлснээр Бирж бүтээгдэхүүнийг хүлээн авах мэдэгдлийг худалдан авагч, эсхүл брокер болон итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 3.11. Худалдагч нь агуулах, терминалаас ачилт хийхээс ажлын 3 хоногийн өмнө энэ талаар итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэж, бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээдийн биеийн байцаалт, чингэлэг, тээврийн хэрэгсэл болон бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийн талаар мэдээллийг урьдчилан итгэмжлэгдсэн агуулах, терминалд хүргүүлнэ.
- 3.12. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь гэрээний дагуу нийлүүлэх бүтээгдэхүүний ачилтыг хийн худалдан авагчид хүлээлгэн өгч акт үйлдэн, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хамт Биржид ирүүлнэ.
- 3.13. Спот гэрээгээр арилжаалах бүтээгдэхүүнийг арилжаа зохион байгуулагдах өдрөөс ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулж, бүртгэсэн байна.
- 3.14. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг хүлээн авах, хүлээлгэн өгөх бүртгэлийг хөтлөх бөгөөд Бирж нь хяналт, шалгалтын зорилгоор бүртгэл, агуулахын баримтыг тухай бүр шалгах эрхтэй байна.
- 3.15. Агуулахын баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн итгэмжлэгдсэн агуулах, терминал хариуцна.

### ***Төлбөр тооцоо***

- 3.16. Худалдан авагч нь өөрийн буруугаас гэрээгээр тогтоосон хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээн аваагүй тохиолдолд агуулах, терминалын төлбөрийг төлөх бөгөөд агуулахын төлбөрийг дараах байдлаар тооцно:
- 3.16.1. агуулах терминалын төлбөрийг тухайн агуулах, терминалын худалдагчтай байгуулсан гэрээнд тусгагдах нөхцөлөөр;
- 3.16.2. худалдан авагч бүтээгдэхүүнийг хугацаа хожимдуулан хүлээн авснаас хойш тухайн агуулах, терминалын нэхэмжлэхийн дүнгээр.
- 3.17. Агуулах, терминалын шаардсан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Биржийн “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам” болон худалдан авагчтай байгуулсан гэрээнд заасан хариуцлагыг худалдан авагчид хүлээлгэнэ.
- 3.18. Итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх үйлчилгээний төлбөрийг худалдагч хариуцна.

### ***Чанарын хяналт***

- 3.19. Худалдагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршуулсан бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийлгэх гэрээг Биржийн итгэмжлэгдсэн лабораторитой байгуулна.
- 3.20. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд төрийн байгууллагын зүгээс

хяналт тавих зорилгоор нийт шинжилгээний дээжийн 10-аас доошгүй хувьд Геологийн судалгаа, шинжилгээний төв шинжилгээ хийж дүгнэлт гаргана.

- 3.21. Итгэмжлэгдсэн лаборатори нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд байршсан бүтээгдэхүүнээс Монгол Улсын холбогдох стандартад заасан аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийнэ.
- 3.22. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалд хүлээн авах болон агуулахаас ачилт хийх үеийн жинг үнэн зөв тооцож, баталгаажуулна.
- 3.23. Итгэмжлэгдсэн лаборатори нь бүтээгдэхүүний чанарын шинжилгээг хийж дууссаны дараа шинжилгээний үр дүнгийн хуудасны эх хувийг агуулах, терминалд, хуулбар хувийг Бирж болон худалдагчид хүргүүлнэ.
- 3.24. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудаст дээжийн мэдээлэл, сорилт, шинжилгээг гүйцэтгэсэн стандарт, шинжилгээ хийсэн үзүүлэлт, зөвшөөрөгдөх хэмжээ, хэмжих нэгж, үр дүнг тусгасан байна.
- 3.25. Итгэмжлэгдсэн агуулах, терминал нь бүтээгдэхүүнийг агуулах, терминалаас ачих үед итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгийн хуудсыг худалдан авагчид хүлээлгэн өгнө.
- 3.26. Чанарын маргаанаас шалтгаалан агуулах, терминалаас ачилт хийгдээгүй тохиолдолд худалдан авагч нь итгэмжлэгдсэн агуулах, терминалд мэдэгдэн ачилтыг түр хойшлуулж болно. Энэ тохиолдолд худалдан авагч нь Биржээс бүтээгдэхүүн хүлээн авах мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор давтан шинжилгээ хийлгэх хүсэлтийг Биржид гаргана. Давтан шинжилгээ хийлгэх хүсэлтэд агуулах, терминалын нэр, бүтээгдэхүүний байршил, тоо хэмжээ, чанарын үзүүлэлт, холбоо барих хаяг болон шаардлагатай бусад мэдээллийг тусгаж, албан ёсны тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Давтан шинжилгээг худалдагч, худалдан авагчийн тохиролцож сонгосон Биржийн итгэмжилсэн шинжилгээний лаборатори гүйцэтгэх бөгөөд давтан шинжилгээний үр дүнгээс хамаарч төлбөрийг худалдан авагч, эсхүл худалдагч хариуцна.
- 3.27. Худалдан авагч нь заасан хугацаанд тогтоосон журмын дагуу давтан шинжилгээ хийлгэх хүсэлт гаргаагүй тохиолдолд агуулах, терминалаас ачсан бүтээгдэхүүний чанарыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.
- 3.28. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газраас баталсан холбогдох стандартаар тогтоосон стандарт хазайлтын хүрээнд багтах тохиолдолд шинжилгээний чанар хангалт шаардлага хангасан гэж үзнэ.
- 3.29. Давтан шинжилгээний дүн болон анхдагч шинжилгээний үр дүн нь зөрүүтэй бөгөөд уг зөрүү нь стандарт хазайлтын хүрээнээс илүү гарсан тохиолдолд худалдагч болон худалдан авагч талуудын хооронд байгуулсан экспортын гэрээ буюу худалдах, худалдан авах гэрээгээр зохицуулна.

## **ДӨРӨВ. БУСАД**

- 4.1. Худалдагч, худалдан авагч талууд нь энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан системд хийгдсэн хэлцлийн нөхцөлийг экспортын гэрээндээ заавал тусгах

бөгөөд бусад нөхцөлийг холбогдох хууль, журамд нийцүүлэн харилцан тохиролцож тогтооно.

- 4.2. Энэхүү журам болон гэрээний хэрэгжилттэй холбоотой гарсан аливаа маргааныг Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх арбитрын шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

---oO---

## АГУУЛАХЫН БАРИМТ

№ ....

20 .... он .... сар .... өдөр

### 1. Бүтээгдэхүүний мэдээлэл

- 1.1. Бүтээгдэхүүний нэр
- 1.2. Бүтээгдэхүүний код
- 1.3. Хэмжээ (тонн)
- 1.4. Бүтээгдэхүүнийг хадгалсан агуулах,  
терминалын дугаар

### 2. Харилцагчийн мэдээлэл

- 2.1. Худалдагчийн нэр
- 2.2. Регистрийн дугаар
- 2.3. Брокерын компанийн нэр
- 2.4. Брокерын нэр
- 2.5. Тээвэрлэгчийн мэдээлэл
- 2.6. Худалдан авагч тодорхой бол нэр

### 3 Агуулах, терминалын мэдээлэл

- 3.1. Нэр
- 3.2. Утас
- 3.3. Агуулахын дугаар


---o0o---